



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР


15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3, Утас: 26-36-28, Факс: 31-03-70
E-mail: info@mram.gov.mn

2015.09.18 № 2/7297
танай 2015.0831 -ны № ХЭГ/1676 -Т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын стандартын дагуу баталгаажуулалтад бэлтгэх ажлын төлөвлөгөөний 1.3, 2.1, 2.3 дугаар заалтад тус тус заасан “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийн хэрэгжилт, бичил уурхай эрхлэлтийн байдал, сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл олгох үйл явц, 2014 онд хийгдсэн томоохон хайгуулын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргүүлж байна.

Хавсралт 9



ДЭД ДАВГЫН ҮҮРЭГИЙН ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.АМАРСАЙХАН

10 04111

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын стандартын дагуу баталгаажуулалтад бэлтгэх ажлын төлөвлөгөөнд туссан мэдээлэл

1.3. “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийн хэрэгжилт

Хуулийн үйлчлэлд нийт **656** ашиглалтын тусгай зөвшөөрөл хамрагдсан. Үүнээс:

- Нүүрсний ашиглалтын тусгай зөвшөөрөл - 79
- БОНХАЖЯ-наас лавлагаа ирүүлээгүй - 138
- БОНХАЖЯ-наас лавлагаа ирүүлсэн - 333
- Кадастрын даргын шийдвэрээр цуцлагдсан - 68
- Засгийн газрын тогтоолоор чөлөөлөгдсөн - 30
- Стратегийн орд – 8

2015.09.14-ний байдлаар БОНХАЖЯ-ны лавлагааг үндэслэн хориглосон хилийн заагтай бүтэн давхцалтай **43** ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлах, Ойн тухай хуулиар шийдвэрлэгдэх **47** ашиглалтын тусгай зөвшөөрөл ойн үнэлгээ хийлгэж, Ойн газраас дүгнэлт гаргуулан, тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Усны тухай хуулиар 200 м хасуулах **17**, энгийн хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулах боломжтой эсэх талаар дүгнэлт гаргуулах /усны сан бүхий газрын хилийн заагтай давхцалтай/ **104** ашиглалтын тусгай зөвшөөрөл байна. Эдгээрээс энэ жилийн хувьд хориглосон талбайн хилийн заагийн гадна олборлолт явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулын ажлын төлөвлөгөө батлагдаж, хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа.

Хориглосон талбайд олборлолт хийж байсан эсэх талаар дүгнэлт гаргуулахаар 10 тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүсэлт ирүүлснийг судлан үзэж байна.

Нийт **122** ашиглалтын тусгай зөвшөөрөл хуулийн үйлчлэлээс гарсан байна.

Засгийн газрын 174 дүгээр тогтоолд хамрагдаж нөхөх олговрыг “0” төгрөгөөр тооцуулж хориглосон талбайтай давхцаж буй хэсгийг хасуулж, солбицолд өөрчлөлт оруулсан 40 тусгай зөвшөөрөл эзэмшигчид Засгийн газрын 2015 оны 120, 289 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан хасуулсан талбайгаа буцаан авах өргөдөл ирүүлээд байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс буцаан өгсөн хориглосон талбайтай давхцалтай хэсэгт орон нутгийн удирдлагууд тушаал, шийдвэр гарган бичил уурхайн зориулалтаар ашиглуулах явдал газар авч байгаа тул хууль бус ажиллагааг зогсоох талаар арга хэмжээ авч өгөх талаар гомдол их ирж байна.

1.3. Бичил уурхай эрхлэлтийн мэдээлэл

Засгийн Газрын 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 308 дугаар тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” батлагдсанаас хойш 2015 оны 05 дугаар сарын 08-ны байдлаар нийт 12 аймгийн 27 суманд 72 талбай буюу нийт 976,13 га талбайг хамарч байна. Өнөөдрийн байдлаар дүгнэлт гарсан 72 талбайгаас 18 талбайг Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар Кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

2012 онд 10 аймгийн 25 талбай буюу 856,55 га, 2013 онд 1 аймгийн 1 сумын 3 талбай буюу 15,87 га, 2014 онд 6 аймгийн 6 суманд 10 талбай буюу 56,21 га, 2015 оны эхний улирлын байдлаар 3 аймгийн 3 суманд 10 талбай буюу 41,99 га газарт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох боломжтой дүгнэлт гараад байна.

Бичил уурхайгаар ашиглах боломжтой гэж гарсан талбайн мэдээлэл
/2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/

Аймаг	Сум	Талбайн нэр	Талбайн хэмжээ /га/	Ажиллаж байгаа эсэх	Ажиллагсдын тоо
1	2	3	4	5	6
Дорноговь	Айраг	Самартайн цагаан дэл	4.9/жонш/	ажиллаж байсан	100 хүн
	Иххэт	Цагаан шороот-1	14.0/жонш/	ажиллаж байсан	50 хүн
		Цагаан шороот-2	4.55/жонш/	ажиллаж байсан	50 хүн
		Цагаан элгэн	20.1/жонш/	ажиллаж байсан	20 хүн
Дундговь	Баянжаргалан	Сүүл-Өндөр 1-р талбай	2.48/жонш/	ажиллаагүй	-
		Сүүл-Өндөр 2-р талбай	4.93/жонш/	ажиллаагүй	-
		Хөх дэл-1	97.4/жонш/	ажиллаагүй	-
		Хөх дэл-2	5/жонш/	ажиллаагүй	-
		Хөх дэл-3	5/жонш/	ажиллаагүй	-
		Нүдэн	7.34/жонш/	ажиллаагүй	-
	Гурвансайхан	Их газрын чулуу	17.4/жонш/	ажиллаагүй	-
	Өлзийт	Ембүү толгой	38.5/жонш/	Орон нутагт аа хүлээлгэн өгсөн.	-
	Хулд	Түймэрт цагаан	117.58 /жонш/	ажиллаж байгаа	15 нөхөр лөл
	Дэлгэрхангай	Шарвагийн усны хяр	49.74 /жонш/	ажиллаагүй	-
Луус	Хадат улаан орчим	47.93 /жонш/	Ажиллаж байсан	200 хүн	
Хэнтий	Батноров	Ухаа овоот	1.9/жонш/	Ажиллаж байсан	15 хүн
		Жавхлант	1.08/жонш/	Ажиллаж байсан	40 хүн
		Өндөр ухаагийн хажуу	1.54/жонш/	Ажиллаж байсан	30 хүн
		Түмэнгийн ар	3.66/жонш/	Ажиллаж байсан	50 хүн
		Салхитын цагаан толгой-1	1.92/жонш/	Ажиллаж байсан	20 хүн
		Чимэдийн хөндлөн	5.87/жонш/	ажиллаагүй	-
		Салхитын цагаан толгой-2	4.22/жонш/	Ажиллаж байсан	20 хүн
	Баян-Адрага	Хөлийн холбоо-1	6.77/жонш/	Ажиллаж байсан	20 хүн
		Хөлийн холбоо-2	5.13/жонш/	Ажиллаж байсан	20 хүн
		Хөлийн холбоо-3	11.5/жонш/	Ажиллаж байсан	20 хүн
		Хөлийн холбоо	50.0/жонш/	Ажиллаж байсан	20 хүн
	Дархан	Чулуутын ам	6.87/жонш/	ажиллаагүй	-
		16-р хүдрийн биетийн орчим	0.79/жонш/	ажиллаагүй	-

		Бор-Өндөр зүүн урд	5.57/жонш/	Ажиллаж байсан	40 хүн
	Хэрлэн	Ихэр	4.67/жонш/	ажиллаагүй	
	Норовлин	Шалз	44.5/жонш/	Ажиллаж байсан	40 хүн
Дархан-уул	Шарын гол	Их шарын гол-1	11.65/ алт/	ажиллаагүй	-
		Цагаан хөтөл	12.59/алт/	ажиллаагүй	-
		Шар хөндий	5 /алт/	ажиллаагүй	-
		Шарын хөндий-1	2.91/алт/	ажиллаагүй	-
		Шарын хөндий-2	59.09/алт/	ажиллаагүй	-
Өвөрхангай	Нарийн тээл	Дунд түрүүний хавирга	3.62 /алт/	ажиллаагүй	-
		Буйлсан сайр	3.2 /алт/	ажиллаагүй	-
		Хараат ягааны баруун жалга	1.12 /алт/	ажиллаагүй	-
		Хараат ягааны өврийн жалга	10.69 /алт/	ажиллаагүй	-
		Уужим булан	5.21 /алт/	ажиллаагүй	-
Булган	Бүрэг хангай	5 дахь талбар	12.49 /алт/	ажиллаагүй	-
		6 дахь талбар	17.99 /алт/	ажиллаагүй	-
Төв	Сэргэлэн	Гурван жалга	5.15	ажиллаагүй	-
		Баруун баруун урт	29.4 /алт/	ажиллаагүй	-
	Батсүмбэр Эрдэнэ	Хуучин угаасан овоолго Уст гозгор	7.99 /алт/ 5.01	ажиллаагүй ажиллаагүй	- -
Орхон	Баян-өндөр		6.12	ажиллаагүй	-
			5.84	ажиллаагүй	-
Сэлэнгэ	Мандал	Рашаантын ам	3.08	Ажиллаж байсан	56 хүн
		Ноён	12.29	ажиллаж байгаа	58 хүн
	Сайхан Хүдэр	Бор толгой уул	5/чулуу/ 20.79 /алт/	ажиллаагүй ажиллаагүй	- -
Архангай	Цэнхэр	Аршанд	6.97	Ажиллаж байсан	100 хүн
	Цэцэрлэг	Хатуу ухаа	6.94	Ажиллаж байсан	4 хүн
10	25 сум	55 талбай	856.55		

2013 онд бичил уурхайгаар ашиглах боломжтой дүгнэлт гарсан талбай

Аймаг	Сум	Талбайн нэр	Талбайн хэмжээ/га/
Хэнтий	Батноров	Ангал	11,27 /жонш/
		Төмөртэй-өндөр-1	1,25 /жонш/
		Төмөртэй-өндөр-2	3,35 /жонш/
1	1	3 талбай	15,87

Бичил уурхайгаар ашиглах боломжтой дүгнэлт гарсан талбайн мэдээлэл
/2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/

Аймаг	Сум	Талбайн нэр	Талбайн хэмжээ /га/	Хэдэн хүн ажиллаж байсан эсэх
Говь-алтай	Есөнбулаг	Ямаан усны ам	13.57 /алт/	36 хүн
Төв	Заамар	Талбай 1	4.93 /алт/	-
		Ар сайрын эх	7,94 /алт/	-
Сэлэнгэ	Мандал	Сэртэн	4,93 /алт/	-

Дорнод	Баянтүмэн	Цулын ухаа	9,99 га	-
Хэнтий	Бор-Өндөр			-
		5 талбай	41,38	36

Бичил уурхайгаар ашиглах боломжтой гэж гарсан талбайн мэдээлэл
/2015 оны 9 дүгээр сарын 1-ний байдлаар/

Аймаг	Сум	Талбайн нэр	Талбайн хэмжээ /га/	Хэдэн хүн ажиллаж байсан эсэх
Төв	Заамар	Өвөр сайр	4,06 / алт/	-
		Ганц хайлааст жалга	4,34 / алт/	-
		Туулын баруун дэнж баян гол	10,62 /алт/	-
		Баян гол	5,66 /алт/	-
		Баян гол адаг	1,35 /алт/	-
		Баян голын адаг	4,71 / алт/	-
		Баян гол адаг	11,25 / алт/	-
		Хэцүүгийн ам	11,84 / алт/	-
Дундговь	Луус	Шаргал	10,01 /жонш/	-
Хэнтий	Батноров	2-р жила	10,33 /жонш/	-
		Өндөр ухаагийн хажуу	1,9 /жонш/	-
Увс	Тариалан	Бор хавцал	2,33 /жонш/	-
Дорноговь	Айраг	Их хонгорын уул	35,01	-
		Бороодой	166,9 /жонш/	-
		Тагт	1,39 /жонш/	-
		Алтад	25,15 /жонш/	-
		Яшил	28,35 / жонш/	-
Ховд	Мөст	Нарийн давын ам	238,01 /жонш/	-
Хэнтий	Дархан	Хажуу улаан	25,79 /вольфрам/	-
Баянхонгор	Заг	Цагаан индэрт	26,31 /жонш/	-
Завхан	Ургамал	Дух	0,02 /алт/	-
		Цагаан толгой	1,75 /алт/	-
			4,02 / алт/	-

Гурвалсан гэрээгээр ажиллаж байгаа талбай: Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутагт байрлах Цагаан цахир алтны үндсэн орд дээр “Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо” ХАМОДХ ТББ нь Спейшлмайнз ХХК-ийн ашиглалтын талбайд бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа бөгөөд орон нутаг, компанитай 2012 оны 11 дүгээр сарын 29-нд гурвалсан гэрээ байгуулан 30 га газарт 55 нөхөрлөлийн 330 иргэн үйл ажиллагаа явуулж байна.

Нийт бичил уурхай эрхлэгчдийн тоо

д/д	Огноо	Нөхөрлөлийн тоо	Гишүүдийн тоо	Боломжтой	
				Дүгнэлттэй талбайд	Хууль бус
1	2010	410	3300	3000	300
2	2011	317	2274	2274	-
3	2012	680	5390	3098	2292
4	2013	787	6383	3400	2983
5	2014	871	7085	4639	2446

Өнөөдрийн байдлаар Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоонд нийт 5800 бичил уурхай эрхлэгчид бүртгэлтэй байна.

Хууль бусаар олборлолт явуулж байгаа газрын мэдээлэл

№	Аймаг	Сум	Талбайн нэр	АМ-ын төрөл
1	Төв	Заамар	Өлийн даваа	Алт
2	Төв	Заамар	Цагаан чулуут	Алт
3	Төв	Сэргэлэн		Алт
4	Өмнөговь	Гурвантэс	Гүн	Улаан чулуу
5	Баянхонгор	Баян-овоо		Алт
6	Баянхонгор	Бөмөгөр		Алт
7	Сэлэнгэ	Ерөө	Бугант тосгон	Алт
8	Сэлэнгэ	Хүдэр		Алт
9	Сүхбаатар	Сүхбаатар	Цагаандэл	Алт
10	Увс	Өмнөговь		Алт
11	Дорноговь	Дэлгэрэх		Алт
12	Ховд	Цэцэг	Цагаан эрэг	Вольфрам
13	Ховд	Алтай		Вольфрам
14	Ховд	Булган		Алт
15	Говь-Алтай	Дэлгэр	Хүрэнтийн амны Улаан толгой	Алт
16	Төв	Сүмбэр	Баруун тахилгат	Алт
17	Увс	Тариалан		Алт
18	Завхан	Ургамал		Алт
19	Завхан	Дөрвөлжин		Алт
20	Ховд	Дөргөн		Алт
21	Говь-Алтай	Есөнбулаг		Алт

Нөхөн сэргээлтийн мэдээ

д/д	Огноо	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ /га/	д/д	Огноо	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ /га/
1	2010	2.0	4	2013	29.0
2	2011	5.0	5	2014	85.21
3	2012	56.53			

Бичил уурхайн зохион байгуулалт

Улсын хэмжээнд 20 аймгийн 76 сум, нийслэлийн 1 дүүрэгт нийт 238 орд газарт гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явагдаж байна. Судалгаанд хамрагдсан 13375 бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх нь алт олборлож байна. Үүнд:

- 10,5 мянга буюу 78,2 хувь нь алт
- 1,4 мянга буюу 10,2 хувь нь нүүрс
- 1,0 мянга буюу 7,6 хувь нь жонш
- 0,3 мянга буюу 2,3 хувь нь гянтболд
- 47 буюу 0,4 хувь нь цагаан тугалга
- 10 буюу 0,1 хувь нь шохойн чулуу
- 0,1 мянга буюу 1,0 хувь нь үнэт чулуу
- 49 буюу 0,4 хувь нь давс олборлож байна.

2.1. Сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл олгох үйл явцын танилцуулга

Монгол Улсын Их хурал 2014 оны 7 дугаар сарын сарын 1-ний өдөр “Ашигт малтмалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баталсан. Хууль батлагдсанаар ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалт явуулж олгох эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд Ашигт малтмалын тухай хуулийн 19.12, 20.1, 24.2, 26.9, 60.9-д заасан үндэслэлээр буюу эрдсийн

хуримтлалтай, тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан, дуусгавар болсон талбайд тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгохоор болсон.

2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Засгийн газрын газрын хуралдаанаас Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам шинэчлэн батлах эрхийг Уул уурхайн сайдад олгосон. Үүний дагуу Уул уурхайн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 10 дугаар тушаалаар “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг баталсан.

Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 239 дүгээр тогтоолоор батласнаар нийт газар нутгийн 19.88 хувьд хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох ба үүний 13.39 хувь буюу 20.9 сая га талбайд өргөдлөөр, 6.49 хувь буюу 10.2 сая га талбайд сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрлийг олгоно.

АМГ нь тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг олон нийтийн хяналтан дор явуулах нөхцлийг хангах үүднээс сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалыг нээхэд оролцогчдыг болон шаардлагатай тохиолдолд хэвлэл мэдээлийн хэрэгслийг байлцуулан ажиллаж байна. Үүнээс гадна

- Сонгон шалгаруулалтын журмыг байгууллагын цахим хуудсанд (www.mram.gov.mn) байршуулсан. Сонгон шалгаруулалтанд шалгарсан оролцогчид сонгон шалгаруулалтад шалгарсан тухай харин бусад оролцогч нарт шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг журмын дагуу хүргүүлдэг.
- “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын дагуу АМГ-ын даргын тушаалаар Сонгон шалгаруулалтын комисс байгуулагдсан.
- АМГ-ын Кадастрын хэлтэсээс ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл болон түүний шилжилт хөдөлгөөн, шинээр олгосон тусгай зөвшөөрөл, талаархи статистик мэдээ, тайлан судалгааг гарган, шаардлагатай мэдээллийг олон нийтэд мэдээлэн, холбогдох газруудад сар бүр хүргүүлэн ажиллаж байна.

2.3. 2014 онд хийгдсэн томоохон хайгуулын үйл ажиллагааны мэдээ

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа сэдэвчилсэн судалгааны төслүүдийн товч танилцуулга

1. Алтай-1 төслийн “1:200 000-ны масштабын агаарын геофизикийн сувгийн /соронзон, уран, тори, кали, нийлбэр/ судалгаа”-ны ажил

Төслийн нэр код: “1:200 000-ны масштабын агаарын геофизикийн сувгийн /соронзон, уран, тори, кали, нийлбэр/ судалгаа”-ны ажил.

Төслийн ажил гүйцэтгэлийн хугацаа, талбайн хэмжээ: 2014 оны 07 сарын 30-наас 2016 оны 11 сарын 30 хүртэл. 119030 кв.км.

Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Бигэр, Чандмань, Баянхонгор аймгийн Баянцагаан, Баян-Өндөр, Баянговь, Богд, Баянлиг, Жинст, Шинэжинст, Өмнөговь аймгийн Гурвантэс сум. L-47-XX, XXI, XXII, XXIII, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, K-47-II, III, IV, V, VIII, IX, X, XI, XV, XVI, XVII, XVIII хавтгайнууд.

Гүйцэтгэгч: Улаанбаатар хотын “ГЕОСАН” ХХК, Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ, зөвлөх геофизикч Н.Дондог, Төслийн ахлагч Г.Мэндсайхан, нягтлан бодогч Ц.Оюунтуяа.

Ажлын үр дүн, явц: Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геофизикийн судалгааны ажлын хамрагдах хүрээг нэмэгдүүлэх, түүнийг нарийвчлах, улс орны эдийн засаг, дэд бүтэц, бүс нутгийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан тухайн бүс нутагт эрдэс түүхий эдийн хангамжийн асуудлыг шийдвэрлэх, төрөл бүрийн ашигт малтмалын тархалт, байршлын зүй тогтлыг тодорхойлж, эрдэс баялгийн нөөцийн хэтийн төлвийг үнэлэх, хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал болон газрын хэвлийн ашиглалт, олборлох үйл ажиллагаа зэрэг асуудлыг зохицуулах, шийдвэрлэхэд суурь мэдээлэл болгон ашиглах үндсэн зорилготой.

Судалгаанд хэрэглэх соронзон орон хэмжих G-823A цезийн магнитометр багажны тохируулга, эталончлолыг хийсэн. Судалгааг явуулах Цесна 208В маркийн онгоцны засвар үйлчилгээний ажлуудыг хийж дуусгасан. Шалгалтын нислэгүүдийг хийсэн. Энэ ажилтай холбогдсон аюулгүй ажиллагааны танилцуулга, зааварчилгааны ажлыг нисэх бүрэлдүүний багт өгч хээрийн ажилд гарахад бэлэн болгосон. Судалгааны талбайтай холбогдсон урьд өмнө явагдсан судалгааны материалуудтай танилцах ажил улсын геологийн фонд болон газрын тосны фондуудад эхэлж байна. Судалгааны талбайд нийт 4040 тууш.км хэмжилтийн нислэгийг хийлээ. Мөн талбайд очих/ирэх болон шалгалтын 3500 км нислэг хийсэн.

Судалгааны ажлын үр дүнг төслийн талбайн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын ерөнхий зүй тогтолтой нь холбох геологи-геофизикийн тайлалтын ажлыг 1:200000-ны масштабын 1 бүтэн листыг хэмжилтийн нислэгээр бүрхэгдсэний дараа эхлэхээр төлөвлөж байна. Боловсруулалтад шаардлагатай компьютер, хэвлэх төхөөрөмж, программ хангамж бэлэн болсон.

2. Алтай-2 төслийн “1:200 000-ны масштабын агаарын геофизикийн сувгийн /соронзон, уран, тори, кали, нийлбэр/ судалгаа”-ны ажил

Төслийн нэр код: “1:200 000-ны масштабын агаарын геофизикийн сувгийн /соронзон, уран, тори, кали, нийлбэр/ судалгаа”-ны ажил.

Төслийн ажил гүйцэтгэлийн хугацаа, талбайн хэмжээ: 2014 оны 08 сарын 07-наас 2016 оны 11 сарын 30 хүртэл. 88064 кв.км.

Ховд аймгийн Булган, Үенч, Алтай, Говь-Алтай аймгийн Алтай, Эрдэнэ, Бигэр, Тонхил, Цээл, Халиун, Цогт, Бугат сум. L-46-XIX, XX, XXI, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXV, XXXVI, L-47-XIX, XXV, XXXI, K-46-VI, XII, K-47-I, VII хавтгайнууд.

Гүйцэтгэгч: Улаанбаатар хотын “Магнетик сурвэй” ХХК, Захирал М.Дүйнхэржав, ерөнхий геофизикч А.Дашбат, нягтлан бодогч Ж.Отгонцэцэг.

Ажлын үр дүн, явц: Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геофизикийн судалгааны ажлын хамрагдах хүрээг нэмэгдүүлэх, түүнийг нарийвчлах, улс орны эдийн засаг, дэд бүтэц бүс нутгийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан тухайн бүс нутагт эрдэс түүхий эдийн хангамжийн асуудлыг шийдвэрлэх, төрөл бүрийн ашигт малтмалын тархалт, байршлын зүй тогтолыг тодорхойлж, эрдэс баялгийн нөөцийн хэтийн төлөвийг үнэлэх, хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал болон газрын хэвлийн ашиглалт, олборлох үйл ажиллагаа зэрэг асуудлыг зохицуулах, шийдвэрлэхэд суурь мэдээлэл болгон ашиглах үндсэн зорилготой.

Түншлэгч компани нисэх онгоцыг оруулж ирэх болон АГС-ын ажилд бэлтгэл хийх үйл ажиллагаа нь хугацаа их шаардах бөгөөд АГС-ны ажил нислэгийн тохиромжтой үе хэдийн өнгөрч уулархаг нутгаар цасан бүрхүүл үүсэн, хүйтэрч хүндэрсэн болон санхүүжилтийн нөхцөл хүндрэлтэй байгаагаас судалгааны хугацааг хойшлуулах санал тавьсан. АГС-ын ажлыг 2015 оны 5-р сарын 1-ээс эхлүүлнэ. Иймээс хээрийн судалгааны ажлын төлөвлөгөөг дахин боловсруулж батлуулна.

Ашигт малтмалын орд, илрэл, эрдэсжсэн цэг, геохимийн болон, шлихийн сарнилын хүрээний мэдээллийг нэгтгэн, дагалдах мэдээллийн санг үүсгэж, зургийг нэгтгэж эхлээд байгаа. Талбайн нийт мэдээлэлийг нэгтгэж ажлын зураг бэлтгэх бөгөөд геологийн зургийг ажлын байдлаар зохиож танилцах маршрут, петрофизикийн болон бусад дээжлэлт, сорьцолтын ажлыг хийж эхлээд байна. Талбайн 1:500 000-ны ашигт малтмалын тойм зургийг анхдагч байдлаар зохиох ажлыг эхлээд байна. Үүнтэй холбоотой газрын судалгааны зарим ажлыг эхлүүлээд байна. Нийт талбайн хэмжээнд өмнөх судалгааны ажлуудын тайлантай танилцан сансрын зургийг бэлдэн тайлалыг хийж эхлэхэд бэлэн болсон. Мөн өмнөх судалгаагаар тогтоогдсон гажуудыг хянан шалгаж байна. Нийт талбайн хэмжээнд хийгдсэн геологийн зураглалын ажил, ашигт малтмалын эрлийн ажлын бүх баримт материалыг нэгтгэж, дагалдах мэдээллийн санг үүсгэж 1:50000-ны ажлын мэдээлэл, хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрэл-хайгуулын түвшний мэдээллийг оруулж эхлээд байгаа

Өнөөгийн байдлаар манай талбайд орших өмнөх судалгааны үр дүнд илэрсэн АГС-ны зарим гажуудыг нарийвчлан шалгаж, талбайн судалгааны ажлаар баталгаажуулах ажлыг явуулж байна.

Хувийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хайгуулын ажлын судалгааны тойм судалгаа

Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 2014 оны эцсийн байдлаар хайгуулын 1389 ш тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байсан. Үүнээс хуулийн дагуу тухайн жилд гүйцэтгэсэн геологи-хайгуулын ажлын тайлангаа ирүүлсэн нь 1014, тайлан ирүүлээгүй нь 239 байна. Түүнээс гадна 50 тусгай зөвшөөрлийн талбайн эцсийн үр дүнгийн тайлан, нөөцийн тооцооллыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн нөөцийг Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн байна. Мөн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан 46, цуцлагдсан 30, талбайгаа бүхэлд нь буцаан өгсөн 2 тусгай зөвшөөрөл байна.

Хувийн хөрөнгөөр 2014 онд хийгдсэн геологи хайгуулын ажлын жилийн тайлан ирүүлсэн байдал

/2015.05.25-ны байдлаар/		
Д/Д	Явц	Тоо хэмжээ /ш/
1	Ирүүлсэн	1014
2	Ирүүлээгүй	239
3	ЭБМЗ-р нөөц оруулсан	50
4	Ашиглалтын тусгай зөвшөөрөл болсон	3
5	Геологийн Албанд албан тоот ирүүлсэн	5
6	Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан	46
7	Тусгай зөвшөөрлийг цуцалсан	30
8	Тусгай зөвшөөрлийг бүхэлд нь буцаасан	2
	Нийт	1389

Монгол улсын хэмжээнд 2014 онд хувийн хөрөнгө оруулалтаар нийтдээ 133,155,213,703.71 төгрөгийн геологи хайгуулын ажил гүйцэтгэсэн байна.

Хувийн хөрөнгөөр 2014 онд хийгдсэн геологи хайгуулын ажлын зардал

№	Ажлын төрөл	Зардал /төг/
1	Бэлтгэл ажил	2,971,888,413.00
2	Зураглалын ажил	2,473,873,725.62
3	Эрлийн маршрут	2,266,785,184.91
4	Сорьцолт	2,156,343,510.35
5	Геофизикийн ажил	11,643,090,154.81
6	Уулын ажил	4,749,742,518.71

7	Өрөмдлөг	66,811,880,789.88
8	Геохимийн ажил	721,642,749.25
9	Лаборатори	8,996,366,329.19
10	Топогеодезийн ажил	1,261,584,299.12
11	Гидрогеологийн ажил	2,165,769,125.22
12	Тээвэр	3,483,964,401.48
13	Суурин боловсруулалт	18,121,498,095.52
14	БОНСэргээлт	1,870,398,940.15
15	Талбайн сорьцлолт	2,177,447,072.08
16	Геоморфологи	-
17	Археологи	122,103,870.00
18	Палеонтологи	83,080,431.67
19	Бусад	1,457,441,176.06
	Нийт	133,155,213,703.71

Хайгуулын ажилд хамгийн их хөрөнгө оруулалт оруулсан аж ахуйн нэгжүүд

№	Компанийн нэр	Ашигт малтмалын төрөл	ТЗ-ын дугаар	Аймаг	Талбайн хэмжээ, хаана	Нийт зардал /төгрөг/
1	"Сонин хад" ХХК	төмөр	12012 х	Төв	5337.5	2,937,699,000
2	"Миллениум сторм" ХХК	зэс, алт	15446х	Төв	11801.37	3,074,523,115
3	"Өү Жи Си Эйч Эл" ХХК	алт, мөнгө, зэс	7560 х	Говь-Алтай	2000.03	3,192,669,450
4	"Эф Ви Эс Пи" ХХК	зэс	13598 х	Говь-Алтай	183145.4	3,591,165,256
5	"Эжбалеи" ХХК	алт зэс	16831а	Дорнод	412.46	5,559,505,020
6	"Надмин" ХХК	зэс, алт	15000х	Дорноговь	22307.11	4,286,459,960
7	"Оюут-Улаан" ХХК	алт, зэс	17387а	Өмнөговь	6647.05	4,437,763,021
8	"АГМ Майнинг" ХХК	зэс, алт	7305 х	Өмнөговь	8010.74	3,524,252,380
9	"Кожеговь" ХХК	уран	11921 х	Дорноговь	17783.99	5,245,979,487
10	"Кожеговь" ХХК	уран	11946 х	Дорноговь	36300.59	12,669,744,089

Өнгөрсөн онд гүйцэтгэсэн хайгуулын ажлуудын үр дүнд Монгол улсын Ашигт малтмалын нэгдсэн санд 12 төрлийн ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлсэн байна. Үүнээс Монгол улсын алтны нөөц 100,241 кг-аар, төмрийн нөөц 35698 тонноор, зэсийн нөөц 44,4 сая тонноор, гянтболдын нөөц 235564 тонноор, газрын ховор элементийн нөөц 811791,6 тонноор /ислээр/, нүүрсний нөөц 6822,33 тонноор, хайлуур жоншны нөөц 4168 тонноор тус тус өссөн болон шинэчлэн бүртгэгдсэн байна.

Уул уурхайн хэлтэс